



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/309

Есөнбулаг сум

Гамшгийн сангаас хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2026 оны 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас хамгаалах команд штабын дадлага сургууль, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах эрүүл мэндийн алба, тохиолдлын удирдлагын тогтолцооны баг, ажлын хэсэгт холбогдох зардлыг хавсралтаар баталсугай.

2.Зардалд шаардагдах 5.672.500 (Таван сая зургаан зуун далан хоёр мянга таван зуун) төгрөгийг гамшгийн сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

